



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



Co-funded by
the European Union



FARO Foundation

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫГ ЧАДАВХЖУУЛАХ ЗАМААР ЦАХИМ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ



Хэрэгжүүлэгч

Пипл ин Нийд ОУТББ



Санхүүжүүлэгч

Европын Холбоо



Засгийн газрын хамтрагч байгууллага:

Цахим Хөгжил, Инновац,
Харилцаа Холбооны Яам



Хамтран

хэрэгжүүлэгч
Фаро Фаундэйшн ТББ



Байршил

Улаанбаатар хот,
Өмнөговь аймаг



Хугацаа

2023-2026



Бичил санхүүжилт

25-35 ИНБ-уудад 5000 хүртэлх
еврогийн санхүүжилт олгоно

“Пипл ин Нийд” ОУТББ нь Фаро Фаундэйшн ТББ болон Цахим хөгжил, Инновац, Харилцаа Холбооны Яамтай хамтран “Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах замаар цахим оролцоог нэмэгдүүлэх нь” төслийг хэрэгжүүлэх ба энэхүү төсөл нь иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулахаас гадна иргэн төвтэй цахим шилжилтийг дэмжиж ажиллана.

Үр шим хүртэгчид:

Төслийн зорилтот орон нутгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, хүүхэд залуус, эмзэг бүлгийнхэнд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг 40 иргэний нийгмийн байгууллага, тэдгээрийн 80 гаруй ажилтан

Цахим бодлого боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн сүлжээ байгууллагууд

Үндсэн зорилго:

Иргэний нийгмийн байгууллагууд хүртээмжтэй цахим шилжилт, ардчилсан тогтолцоонд Монгол Улсын Засгийн газрын Цахим Үндэстэн болох зорилтод нийцүүлэн идэвх санаачилгатай хамтран ажиллаж, бие даасан оролцогчид болох.

Төслийн үр дүн 1

Зорилтот бүлгүүдтэй хамтран ажилладаг ИНБ-ууд өөрсдийн байгууллагын цахим аюулгүй байдлыг хангах, өөрчлөлтөд дасан зохицоход шаардлагатай ур чадвар, нөөц боломжийг олж авна. Үүнээс гадна зорилтот бүлгүүдтэй ажиллах замаар цахим хуваагдлын үндсэн шалтгааныг арилгах ур чадварыг эзэмшинэ.



ИНБ -уудын дотоод чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх

Цахим шилжилтийн боломжууд, цахим эрсдэлүүд ба аюулгүй байдлын талаар сонгогдсон ИНБ-уудад зориулсан сургалт, техник арга зүйн зөвлөгөө, менторын үйл ажиллагааг явуулна.



Иргэдийн цахим бичиг үсгийн боловсролыг дэмжих чиглэлээр ИНБ-уудын мэдлэг, ур чадвар олгох

- Цахим технологиор дамжуулан ардчилсан үйл явцад иргэний оролцоог нэмэгдүүлэх, зорилтот бүлгийн цахим болон мэдээллийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр
- ИНБ-уудаас сургагч багшийг сургаж бэлтгэнэ.



Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх ИНБ-ын санаачилсан үйл ажиллагааг дэмжих

- Цахим орчинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн цахим болон мэдээллийн ур чадвар, чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ИНБ-уудын санаачилга, үйл ажиллагаанд бичил санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Төслийн үр дүн 2

Засгийн газрын оролцогч талуудтай хамтран бодлогын түвшинд цахим шилжилттэй холбоотой цахим хуваагдлыг арилгах чиглэлээр ажиллах ИНБ болон ИНБ-ын сүлжээний чадавхыг бэхжүүлэхэд дэмжиж ажиллана.



Цахим шилжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын хүрээ боловсруулах

Цахим шилжилттэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор судалгаа хийх, удирдамж боловсруулах, мөн цахим бодлогыг хүртээмжтэй болгох, цахим засаглалын тогтолцоог бүрдүүлэхэд ИНБ-уудын үр дүнтэй оролцоог дэмжинэ.



Бодлогын хэлэлцүүлэг, хамтын нөлөөлөл хийхэд иргэний нийгмийг дэмжиж ажиллах

- Хамтарсан бодлого боловсруулах, цахим шилжилттэй холбоотой хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого/зохицуулалт, хэлэлцүүлгийг ажиглах, хянах ба ИНБ-ын оролцоог хангах, чадавхыг хөгжүүлэн, дэмжинэ.



Бодлогын нөлөөлөл хийх ИНБ-уудын санаачилсан үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх

- Цахим бодлогын хүртээмжийг нэмэгдүүлэх, бодлогын хэлэлцүүлэг болон хууль эрх зүйн орчныг хянах зорилгоор ИНБ болон ИНБ-уудын сүлжээний санаачилсан бодлогын нөлөөлөл, кампанит үйл ажиллагаанд бичил санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.